“Төрийн банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
Хараат бус гишүүн С.Цэнд-Аюушийн
2021 оны сүүлийн хагас жилийн ажлын тайлан

Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2021 оны 86 тоот тушаалаар батлагдсан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын дагуу “Төрийн банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүний үүргийг гүйцэтгэж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 16 удаагийн хуралд биечлэн оролцож, банкны удирдлагуудад тусгайлсан асуулга тавьж хариулт авах, ТУЗ-ийн хурлаас гарах шийдвэрт өөрийн санал дүгнэлтээ тусгуулан, зарим асуудлаар зөвлөх үүрэг гүйцэтгэж ажиллаа.

Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хорооны хурлыг 3 удаа даргалж хуралдуулсан бөгөөд хурлаар Эрсдэлийн удирдлагын чиглэлээр 2021 оны 1, 2, 3 дугаар улиралд Зээлийн эрсдэлийн удирдлага, Зах зээл, хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын чиглэлээр банкнаас хийж гүйцэтгэсэн ажлын тайлангуудыг Эрсдэлийн удирдлагын асуудал эрхэлсэн хорооны хурлаар хэлэлцэж, банканд учирч болох эрсдэлд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох, цаашид зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нийт активд эзлэх чанаргүй зээлийг бууруулах талаар чиглэл гарган банкны холбогдох удирдлага болон хариуцсан газар нэгжийн хариуцлагыг нэмэгдүүлэх, ялангуяа цар тахлын дараа эдийн засгийг сэргээх ажлын хүрээнд банкнаас олгогдож байгаа зээлийн хэмжээ өсөж байгаа энэ цаг үед эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар анхааран ажилласан, мөн тус хорооны хурлаар өмнө өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэн хяналт тавьж ажилсан.
- Төрийн банкны чанаргүй зээлийн эргэн төлөлтийн байдал судалгаа хийж зээл төлүүлэх график төлөвлөгөө гарган зээлийн төлөлтийг тодорхой ажилтнаар хариуцуулан ажиллаж байна. Ажлын үр дүн 3 дугаар улирлаас гарч эхэлсэн бөгөөд нийт 5.6 тэрбум төгрөг төлөгдсөн.
- Банкны хэмжээнд тулгамдаж байгаа асуудлаар стресс тест ашиглаж эрсдэлийн үнэлгээ хийж байх үүрэг өгөгдсөний дагуу банк үнэлгээ хийж байна.
- ЭУАЭХорооны 2021 онд хийсэн ажлын тайланг ТУЗ-ийн хуралд танилцуулсан.
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 3 удаагийн хуралд хорооны гишүүний хувиар оролцож Төрийн банкны 2020 оны аудитлагдсан санхүүгийн үйл ажиллагааны тайлан, Дотоод аудитын газрын 2021 оны 2, 3 дугаар улирлын ажлын тайланг хэлэлцсэн бөгөөд алдагдалтай ажиллаж байгаа салбаруудыг ашигт ажиллагаанд шилжүүлэх, ангилагдсан болон чанаргүй зээлийг төлүүлэх, ашиглан залилан гаргуулахгүй байх чиглэлээр үүрэг даалгавар өгсөн.

- Төрийн банкны 2022-2024 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2022 оны бизнес төлөвлөгөөний төслийг хэлэлцэхэд зардал бууруулах, чанаргүй зээлийн хувь хэмжээг бууруулах, худалдан авах хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-ийн хуралд тодорхой танилцуулах, шинэ сэргэлтийн бодлогыг төлөвлөгөөний төсөлд тусгах зэрэг санал гаргасан болно.
- ТУЗ-ийн шийдвэрийн дагуу Төрийн банк ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх бэлтгэлийг хангах ажлын хэсэгт орж ажилласан.

Миний бие банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэг хариуцлагын дагуу ээлжит хуралд тухай бүр биечлэн оролцож банкны Дунд хугацааны стратеги төлөвлөгөө болон 2022 оны бизнес төлөвлөгөөг батлах, банкийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, банкны хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой ТУЗ-өөр хэлэлцэгдэж байгаа бүхий л асуудалд өөрийн санал, дүгнэлтээ бусад гишүүдээс хараат бусаар гаргаж, албан үүргээ бүрэн биелүүлэн ажиллаж байна.

Тайлан бичсэн: С.Цэнд-Аюуш /ТУЗ-ийн хараат бус гишүүн/